



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 114

Шивээговь сум

Газрын солбилцол, талбайн хэмжээнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.3, 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоол “Төлөвлөгөө батлах тухай”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны А/187 тоот “Журам батлах тухай” тушаалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Повер ван глобал лимитед ХХК-ийн “Цахилгаан станц”-ын зориулалтаар эзэмшиж буй газрын талбайн хэмжээ, солбилцолд нь өөрчлөлт орж байгаа тул сумын Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/84 дугаар “Газар эзэмшүүлэх тухай” захирамжийн 1 дэх заалт “....Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Шивээ Овоо уурхайн баруун хойд талд “Цахилгаан станц”-ын зориулалтаар 60 га газрыг Повер ван глобал лимитед ХХК-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй” гэснийг “Газрын солбилцлыг 21 дүгээр зөрлөгийн хойд талд, талбайн хэмжээг 50 га болгон өөрчилж, Повер ван глобал лимитед ХХК-д “Цахилгаан станц”-ын зориулалтаар 7 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй” гэж өөрчилсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшиж буй газрынхаа орчныг эрүүл, хог хаягдалгүй байлгаж, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, ногоон байгууламжийг бий болгон Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг Повер ван глобал лимитед ХХК-ийн захирал (Н.Чинзориг)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч Повер ван глобал лимитед ХХК-ийн захирал Н.Чинзоригтой газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/84 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ



421220039